



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/68

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.10, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн иргэдийг эрүүл, аюулгүй, ая тухтай амьдрах орчин нөхцөлөөр хангах хүрээнд хот, нийтийн аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилтэд үзлэг, шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, орчны аюулгүй байдлыг сайжруулах, нийтийн эзэмшлийн талбайн өнгө үзэмжийг дээшлүүлэх, 2026 онд хэрэгжүүлэх тохижилт, ногоон байгууламж, хог хаягдлын менежмент, инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангаж ажиллахыг ажлын хэсэг (Г.Дагвадорж)-т үүрэг болгосугай.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 01 дугаар сарын 17 -ны өдрийн
8768... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:

Г.Дагвадорж

Дүүргийн менежер

Гишүүд:

Д.Хүрэлбаатар

Засаг даргын Тамгын газрын
хотын стандарт, тохижилт,
нийтийн аж ахуйн хэлтсийн
дарга

Ч.Магадсайхан

Газар зохион байгуулалтын
албаны дарга

Б.Гэрэлмаа

“Багахангай тохижилт”
ОНӨААТҮГ-ын Захирал

Ч.Батхуяг

“Багахангай гэрэлтүүлэг, ногоон
байгууламж” ОНӨААТҮГ-ын
захирал

Д.Гантулга

“Илч-Орд” ОНӨААТҮГ-ын
захирал

Ц.Болд

Багахангай “Ус суваг товчоо”-
ны дарга

Д.Билгээ

Багахангай дүүргийн Замын
цагдаагийн тасгийн дарга

Б.Хишиг-Ундрал

Багахангайн теле камерын
хяналтын дэд төв ОНӨААТҮГ-
ын дарга

Н.Нямзав

1 дүгээр хорооны Засаг дарга

Б.Батзориг

2 дугаар хорооны Засаг дарга

Нарийн бичгийн
дарга:

Б.Дүүрэнжаргал

Засаг даргын Тамгын газрын
Хотын стандарт,
тохижилт, нийтийн аж ахуйн
хэлтсийн мэргэжилтэн



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн
Агс... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ХОТ НИЙТИЙН АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР АВЧ
ХЭРЭГЖҮҮЛЭХ А/01 АЛБАН ДААЛГАВАРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2026.04.15

Багахангай дүүрэг

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа							
			4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар
1	Худалдаа үйлчилгээ эрхлэх байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулж, өнгө үзэмжийг сайжруулах, фасад, гадна орчны угаалга цэвэрлэгээ хийлгэж, тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлах арга хэмжээ зохион байгуулах	ХСТНААХ Хороод Худалдаа үйлчилгээ эрхлэгчид								
2	Дүүргийн өнгө үзэмжийг сайжруулах хүрээнд гэрлэн чимэглэл бүхий ногоон байгууламжийг тодорхой байршилд нэмэгдүүлэн, мөн хаяг, хаягийн байгууламжийг хотын стандартад нийцүүлж жишиг гудамж бий болгох	ХСТНААХ ГНБ ОНӨААТҮГ БТ ОНӨААТҮГ								
3	Явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулж буй шон, гадас, хаалт, хашлага зэргийг буулгаж аюулгүй байдлыг хангуулах, сул шороон хөрс бүхий газрыг зүлэгжүүлэх	БТ ОНӨААТҮГ ГНБ ОНӨААТҮГ								
4	Гуу жалга далан сувгийн ахуйн хог хаягдлыг бүрэн цэвэрлүүлэх шар усны үерээс сэргийлэх, далан сувгийн урсцыг сайжруулах бэлтгэл хангах	БТ ОНӨААТҮГ								
5	Хөрсний болон агаарын бохирдлоос сэргийлэх хүрээнд гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлонг ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг мэргэжлийн, тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах	ХСТНААХ Цеф трейд ХХК Хороод								

[illegible]

	шинэчилж солих, өнгө үзэмж, аюулгүй байдлыг хангуулах, авто зам, явган замын байгууламжид хийгдсэн худгийн тагуудын түвшин тааруулах ажлыг 2 дугаар улиралд багтаан засварлаж, шинэчлэх, тэдгээрт шаардагдах зардлыг байгууллагын төсвөөс шийдвэрлэхийг ашиглалт хариуцсан инженерийн хангамжийн байгууллагууд	УСАТ УБТЗ-ын БЗАУ- ний ангийн Багахангай хэсэг ААНБ							
14	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд болон орон сууцны хороолол дотор байгаа хогийн бункер, цинкэн савнуудыг будаж засварлах, өнгө үзэмжийг сайжруулах, ариутгаж халдваргүйжүүлэх	БТ ОНӨААТҮГ							
15	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн шон, замын хөдөлгөөний гэрлэн дохионы шонгуудын унжсан болон ил байгаа утас, цахилгааны болон шилэн кабелиудыг цэгцлэх, тагжуулах зэргээр иргэдийн аюулгүй байдлыг хангуулж ажиллах	ЗДТГ ГНБ ОНӨААТҮГ Багахангайн Теле камер хяналтын төв ОНӨААТҮГ							
16	Барилга, замын ажил гүйцэтгэхэд техникийн ерөнхий шаардлага, барилгын ажилд тавих аюулгүйн ерөнхий шаардлагыг хангуулж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах	ХСТНААХ							
17	Албан даалгаврын хэрэгжилтийг хангуулж, хэрэгжилтийн үр дүнг улирал бүр тайлагнаж ажиллах	ААНБ							